# ГАРЧИГ


1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА....3
1.1. Уурхайн жилийн хүчин чадал, горим ба ашиглалтын хугацаа....6
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА....19
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ....22
3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт....22
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ....25
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ....27
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ....32
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ....33
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ....34
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ....34
10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ....35
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ....37
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР....39
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ....41
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ....42

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Талбайн булангийн цэгүүд ....4
Хүснэгт 2.Сэртэн шороон ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт....6
Хүснэгт 3. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо ....8
Хүснэгт 4. Уулын ажлын кадендарчилсан төлөвлөлт....9
Хүснэгт 5. Уурхайн уулын ажил явагдах дараалал ....9
Хүснэгт 6. Уурхайн нээлтийн төлөвлөгөө ....10
Хүснэгт 7. Уурхайн эхний жилийн 1-р хагасын уулын ажлын хэмжээ ....13
Хүснэгт 8. Уурхайн эхний жилийн II хагасын уулын ажлын хэмжээ....14
Хүснэгт 9. Уурхайн 2-р жилийн I хагасын уулын ажлын хэмжээ....16
Хүснэгт 10. Уурхайн 2-р жилийн сүүлийн хагасын уулын ажлын хэмжээ ....17
Хүснэгт 11. Тоног төхөөрөмжийн иж бүрдэл ....18
Хүснэгт 12. Байгаль орчны сөрөг нөлөөллийн үзүүлэлтүүд ....22
Хүснэгт 13. 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал 25
Хүснэгт 14. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ....27
Хүснэгт 15. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө ....32
Хүснэгт 16. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ....33
Хүснэгт 17. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө ....35
Хүснэгт 18. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө....37
Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ....39
Хүснэгт 20. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө....41
Хүснэгт 21. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө ....42

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг ....5
Зураг 2. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг ....5
Зураг 3. Уурхайн байршлын бүдүүвч зураг ....8
Зураг 4. Ил уурхай 3- ийн нээлт....10
Зураг 5. Ил уурхай 2- ийн нээлт....11
Зураг 6. Ил уурхай 1- ийн нээлт....11
Зураг 7. Ил уурхай 4- ийн нээлт....12
Зураг 8. Уурхайн 1-р жилийн I хагасын эцсийн байдал....13
Зураг 9. Уурхайн 1-р жилийн II хагасын эцсийн байдал ....15
Зураг 10 . Уурхайн 2-р жилийн 1-р хагасын эцсийн байдал ....16
Зураг 11. Уурхайн 2-р жилийн 2-р хагасын эцсийн байдал ....17

# 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр:** MV-022824 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй "Сэртэн" нэртэй газарт алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл.

**Төслийн зорилго:** "Тост нутаг" ХХК нь Баянхонгор аймгийн Баян-Овоо, Өлзийт сумдын нутгийг дамнан орших Сэртэн нэртэй алтны шороон ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах ашиглалтын үйл ажиллагааны явцад байгальд орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, нөөцийг хаягдал багатайгаар бүрэн ашиглах, техник тоног төхөөрөмжийн харилцан хамаарал зохицолдлогоо хангаж ашиглалтын зардлыг бага байлгах, эрүүл аюулгүй үйл ажиллагааг явуулахад энэхүү төслийн зорилго оршино.

**Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.** Төсөл хэрэгжүүлэгч "Тост нутаг" ХХК нь 2021 төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа хийх чиглэлээр үүсгэн байгуулагдсан 100% дотоодын хөрөнгө оруулалттай үндэсний компани юм.

**Төсөл хэрэгжүүлэгчийн тухай товч мэдээлэл**

| | |
|---|---|
| Төсөл хэрэгжүүлэгч : | "Тост нутаг" ХХК |
| Регистрийн дугаар: | 6663931 |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9019086077 |
| Хариуцлагын хэлбэр: | Гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| Хуулийн этгээдийн байршил: | СБД, 3-р хороо, 5-р хороолол, хд37, 208 |
| Холбоо барих утас: | 312483 |

**Тусгай зөвшөөрөл:** Ашигт Малтмал, Газрын Тосны Газраас "Тост нутаг" ХХК-нд АМГТГ -ын даргын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн шийдвэрээр Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт Цахирууд нэртэй газарт орших 687.13 гектар талбайд ашигт малтмалын ашиглалтын MV-022824 тоот тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаагаар буюу 2054 оны 10 сарын 09-ний өдөр дуустал хугацаагаар олгосон байна.

- Нөөц хүлээн авч, бүртгэх тухай Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 06-р сарын 27-ны өдрийн н/40 тоот тушаал
- ЭБМЗ-ийн 2024 оны 05-р сарын 31-ний өдрийн хурлын XX-06-02 тоот дүгнэлт,

**Төслийн байршил**

"Сэртэн" нэртэй алтны шороон орд байрлаж буй талбай нь засаг захиргааны хуваариар Баянхонгор аймгийн Өлзийт сумын дамнан орших бөгөөд Түйн голын сав газарт харьяалагдана. Тус орд нь Баянхонгор аймгийн төвөөс 25 км-т, Өлзийт сумын төвөөс 14 км-т орших ба ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 687.13 га талбайг хамран оршино.

Хүснэгт 1. Талбайн булангийн цэгүүд

| № | Уртраг | Өргөрөг | № | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|---|---|---|
| 1 | 100° 38' 4" | 46° 4' 53" | 21 | 100° 43' 17" | 46° 2' 22" |
| 2 | 100° 36' 1" | 46° 4' 53" | 22 | 100° 44' 13" | 46° 2' 22" |
| 3 | 100° 36' 1" | 46° 4' 35.18" | 23 | 100° 44' 13" | 46° 2' 4.18" |
| 4 | 100° 37' 28" | 46° 4' 35.18" | 24 | 100° 45' 14.82" | 46° 2' 4.18" |
| 5 | 100° 37' 28" | 46° 4' 14.97" | 25 | 100° 45' 8.09" | 46° 2' 22" |
| 6 | 100° 38' 36.34" | 46° 4' 14.97" | 26 | 100° 44' 33" | 46° 2' 22" |
| 7 | 100° 38' 36.34" | 46° 3' 58.45" | 27 | 100° 44' 33" | 46° 2' 41.4" |
| 8 | 100° 39' 8" | 46° 3' 58.45" | 28 | 100° 43' 25.3" | 46° 2' 41.4" |
| 9 | 100° 39' 8" | 46° 3' 35.5" | 29 | 100° 43' 25.3" | 46° 2' 58" |
| 10 | 100° 39' 46" | 46° 3' 35.5" | 30 | 100° 42' 39.6" | 46° 2' 58" |
| 11 | 100° 39' 46" | 46° 3' 13.04" | 31 | 100° 42' 39.6" | 46° 3' 16.7" |
| 12 | 100° 40' 13.13" | 46° 3' 13.04" | 32 | 100° 40' 41.5" | 46° 3' 16.7" |
| 13 | 100° 40' 13.13" | 46° 3' 30.85" | 33 | 100° 40' 41.5" | 46° 3' 35.71" |
| 14 | 100° 40' 40.97" | 46° 3' 30.85" | 34 | 100° 39' 58.31" | 46° 3' 35.71" |
| 15 | 100° 40' 40.97" | 46° 3' 7.04" | 35 | 100° 39' 58.31" | 46° 3' 53.5" |
| 16 | 100° 42' 4.49" | 46° 3' 7.04" | 36 | 100° 39' 19" | 46° 3' 53.5" |
| 17 | 100° 42' 4.49" | 46° 3' 15.86" | 37 | 100° 39' 19" | 46° 4' 13" |
| 18 | 100° 42' 38.75" | 46° 3' 15.86" | 38 | 100° 38' 50" | 46° 4' 13" |
| 19 | 100° 42' 38.75" | 46° 2' 38.7" | 39 | 100° 38' 50" | 46° 4' 33" |
| 20 | 100° 43' 17" | 46° 2' 38.7" | 40 | 100° 38' 4" | 46° 4' 33" |

Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг




Зураг 2. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг



## 1.1.Уурхайн жилийн хүчин чадал, горим ба ашиглалтын хугацаа

### Ашигт малтмалын ордын тодорхойлолт

“Сэртэн” алтны шороон ордын нөөцийн тооцооны үр дүнг доор үзүүллээ. Нөөц бодогдсон талбайн урт 11050 м, дундаж өргөн 35 м байна. Хайгуулын 44 шугаманд 150-200х10-20 метрийн торлолоор 119 шурф малтаж түүний үр дүнгийн мэдээллийг нэгтгэн боловсруулж бодитой (В) нөөцийн 31 хэсэглэл, боломжтой (С) нөөцийн 6 хэсэглэлд хувааж нөөцийг тооцоолжээ.

Хүснэгт 2.Сэртэн шороон ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

| Хэсэглэлийн дугаар, нөөцийн зэрэг | Зузаан, м | | Дундаж агуулга, мг/м$^3$ | Хэсэглэлий н талбай, мян.м$^2$ | Эзлэхүүн, мян.м$^3$ | | Металлын нөөц, кг | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хучаас | Элс | | | Хучаас | Элс | Шлих | Цэвэр |
| C-1 | 1.20 | 0.20 | 80 | 0.57 | 0.68 | 0.11 | 0.01 | 0.01 |
| B-2 | 2.90 | 0.30 | 248 | 10.70 | 31.03 | 3.21 | 0.80 | 0.74 |
| B-3 | 3.47 | 0.37 | 336 | 14.08 | 48.81 | 5.16 | 1.74 | 1.61 |
| B-4 | 3.60 | 0.37 | 323 | 12.30 | 44.28 | 4.51 | 1.46 | 1.35 |
| B-5 | 3.65 | 0.45 | 342 | 8.05 | 29.38 | 3.62 | 1.24 | 1.15 |
| B-6 | 2.50 | 0.70 | 258 | 7.24 | 18.10 | 5.07 | 1.31 | 1.21 |
| B-7 | 2.20 | 0.60 | 253 | 7.44 | 16.37 | 4.46 | 1.13 | 1.04 |
| B-8 | 2.40 | 0.30 | 542 | 3.26 | 7.82 | 0.98 | 0.53 | 0.49 |
| B-9 | 2.20 | 0.60 | 218 | 3.25 | 7.15 | 1.95 | 0.43 | 0.39 |
| B-10 | 1.60 | 0.60 | 179 | 5.76 | 9.22 | 3.46 | 0.62 | 0.57 |
| B-11 | 1.56 | 0.48 | 151 | 10.19 | 15.90 | 4.89 | 0.74 | 0.68 |
| B-12 | 1.68 | 0.48 | 155 | 9.76 | 16.40 | 4.68 | 0.73 | 0.67 |
| B-13 | 1.60 | 0.47 | 181 | 5.15 | 8.24 | 2.40 | 0.43 | 0.40 |
| B-14 | 1.47 | 0.47 | 281 | 5.27 | 7.73 | 2.46 | 0.69 | 0.64 |
| B-15 | 1.45 | 0.35 | 303 | 7.25 | 10.51 | 2.54 | 0.77 | 0.71 |
| B-16 | 1.20 | 0.27 | 270 | 5.24 | 6.29 | 1.40 | 0.38 | 0.35 |
| B-17 | 1.30 | 0.40 | 238 | 3.90 | 5.07 | 1.56 | 0.37 | 0.34 |
| B-18 | 1.20 | 0.50 | 182 | 7.31 | 8.77 | 3.66 | 0.67 | 0.62 |
| C-19 | 1.07 | 0.47 | 182 | 4.02 | 4.29 | 1.88 | 0.34 | 0.32 |
| C-20 | 1.60 | 0.40 | 193 | 3.20 | 5.12 | 1.28 | 0.25 | 0.23 |
| C-21 | 1.50 | 0.40 | 401 | 3.99 | 5.99 | 1.60 | 0.64 | 0.59 |
| C-22 | 1.50 | 0.40 | 544 | 4.86 | 7.29 | 1.94 | 1.06 | 0.98 |
| C-23 | 1.93 | 0.40 | 214 | 3.46 | 6.69 | 1.38 | 0.30 | 0.27 |
| B-24 | 1.70 | 0.47 | 183 | 9.95 | 16.92 | 4.64 | 0.85 | 0.79 |
| B-25 | 1.50 | 0.50 | 158 | 7.14 | 10.71 | 3.57 | 0.56 | 0.52 |
| B-26 | 1.93 | 0.27 | 304 | 6.55 | 12.66 | 1.75 | 0.53 | 0.49 |
| B-27 | 1.60 | 0.44 | 309 | 10.76 | 17.22 | 4.73 | 1.46 | 1.35 |
| B-28 | 1.56 | 0.56 | 335 | 10.31 | 16.08 | 5.77 | 1.93 | 1.79 |
| B-29 | 1.75 | 0.40 | 449 | 7.37 | 12.90 | 2.95 | 1.32 | 1.22 |
| B-30 | 1.93 | 0.27 | 401 | 5.82 | 11.25 | 1.55 | 0.62 | 0.58 |
| B-31 | 2.07 | 0.27 | 1040 | 5.03 | 10.40 | 1.34 | 1.39 | 1.29 |
| B-32 | 0.87 | 0.47 | 814 | 5.92 | 5.13 | 2.76 | 2.25 | 2.08 |
| B-33 | 0.87 | 0.47 | 778 | 3.61 | 3.13 | 1.68 | 1.31 | 1.21 |
| B-34 | 0.80 | 0.33 | 472 | 6.14 | 4.91 | 2.05 | 0.97 | 0.89 |
| B-35 | 1.10 | 0.30 | 239 | 7.99 | 8.79 | 2.40 | 0.57 | 0.53 |
| B-36 | 1.35 | 0.45 | 466 | 7.64 | 10.31 | 3.44 | 1.60 | 1.48 |
| B-37 | 1.27 | 0.40 | 700 | 5.30 | 6.71 | 2.12 | 1.48 | 1.37 |

| Хэсэглэлийн дугаар, нөөцийн зэрэг | Зузаан, м | | Дундаж агуулга, мг/м$^3$ | Хэсэглэлий н талбай, мян.м$^2$ | Эзлэхүүн, мян.м$^3$ | | Металлын нөөц, кг | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хучаас | Элс | | | Хучаас | Элс | Шлих | Цэвэр |
| B+C 37 | 1.91 | 0.43 | 319 | 245.78 | 468.24 | 104.96 | 33.46 | 30.95 |
| B зэргээр 31 | 1.94 | 0.43 | 319 | 225.68 | 438.19 | 96.77 | 30.87 | 28.55 |
| C зэргээр 6 | 1.50 | 0.41 | 316 | 20.10 | 30.06 | 8.19 | 2.59 | 2.40 |

**Ил уурхай**

Сэртэн ордын уул-геологи болон уул-техникийн нөхцөлийг харгалзан авто тээвэртэй, хөрсний гадаад дотоод овоолготой ашиглалтын систем хэрэглэн ил уурхайн аргаар ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар сонгосон байна.

Дунд зэргийн болон бага хүчин чадалтай шороон ордуудад ихэнхдээ гидравлик экскаватор болон өөрөө буулгагч автосамосвалын хослолыг ашиглах нь уулын ажлын зохион байгуулалт, механикжуулалт талаасаа тохиромжтой байдаг.

Нөөцийг хэсэгшлүүд дэх хучаас хөрсний зузаан харьцангуй өөр байгаа бөгөөд 1.5 м-ээс бага хучаас хөрсний зузаантай хэсгүүдийн хөрс хуулалтын ажилд бульдозерь ашиглах бол түүнээс дээш зузаантай хэсгүүдэд экскаватор автосамосвалын хослолыг ашиглахаар байна.

**Ил уурхайн хүрээ хязгаар**

Сэртэн нэртэй алтны шороон орд нь нийт 11 орчим км үргэлжлэн тогтсон бөгөөд нөөцийн 4 тусдаа хэсэгт нийт 37 нөөцийн хэсэгшилд нөөц тооцоологдсон байдаг. Гэвч Баянхонгор аймгийн нисэх онгоцны буудлын нөлөөллийн бүсэд хамаарч байна гэх үндэслэлээр нөөц тооцоолсон 1-р хэсгээс B-1 хэсэгшлээс B-7 блокийн хагас хүртэлх хэсгийг хасаж ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон байдаг. Иймд эдгээр нөөцийн хэсэгшлүүдэд ил уурхайн үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон.

Сэртэн нэртэй алтны шороон орд нь геологийн тогтцын хувьд III бүлгийн ордод хамаарах тул Уул уурхайн сайдын 2015 оны 09-р сарын 11-ний өдрийн 203 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын дагуу ордын бодитой /B/ болон боломжтой /C/ нөөцөд тулгуурлан уг ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах боломжийг бий болгож байгаа юм. Иймд бид ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд хамаарч буй нийт 31 нөөцийн хэсэгшлийн хүрээнд ил уурхайг загварчилсан.

**Үйлдвэрлэлийн нөөц**

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд хамаарч буй нөөцийг ашиглахад нийт 6.1 км нийлбэр урттай 4 тусдаа уурхай үүсэхээр төлөвлөгдсөн.

1. Тусгай зөвшөөрлийн талбайн зүүн жигүүр дэх ил уурхай-1 нь B-7-оос C-19 хэсэгшил хүртэл нийт 13 нөөцийн хэсэгшил хамаарах бөгөөд ба уурхайн дундаж өргөн 40 м, урт нь 2.3 км, дундаж гүн 2.2 м байна.
2. Тусгай зөвшөөрлийн талбайн төвийн зүүн хэсэг дэх уурхай-2 нь C-20, C-21, C- 22 гэсэн нөөцийн 3 хэсэгшилд хамаарах бөгөөд уурхайн өргөн 50 м, урт нь 660 м гүн 2 м байна.

3. Тусгай зөвшөөрлийн талбайн төвийн баруун хэсгийн уурхай-3 нь C-23-с B-31 хүртэл нийт 9 нөөцийн хэсэгшлийг хамрах бөгөөд уурхайн дундаж өргөн 40- 50м, урт нь 1.7 км, гүн нь 2.2 м байна.
4. Тусгай зөвшөөрлийн талбайн баруун хэсгийн уурхай-4 нь B-32-с B-37 блок хүртэл нийт 6 нөөцийн хэсэгшилд хамаарах бөгөөд уурхайн дундаж өргөн 50- 60м, урт нь 1,1 км, гүн нь 1.5 м байна.

Хүснэгт 3. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

| № | Ашиглалтын жилүүд | Үе шат | Уурхайн дугаар | Хамаарах нөөцийн хэсэгшил |
|---|---|---|---|---|
| 1 | I жил | I хагас | Ил уурхай-3 | B-26, B-27, B-28, B-29, B-30, B-31 |
| | | II хагас | Ил уурхай-3 | B-25, B-24, C-23 |
| | | | Ил уурхай-2 | C-20, C-21, C-22 |
| | | | Ил уурхай-1 | B-17, B-18, C-19 |
| 2 | II жил | I хагас | Ил уурхай-1 | B-7, B-8, B-9, B-10, B-11, B-12, B-13, B-14, B-15, B-16 |
| | | II хагас | Ил уурхай-4 | B-32, B-33, B-34, B-35, B-36, B-37 |

Зураг 3. Уурхайн байршлын бүдүүвч зураг




**Ашиглалтын үеийн хаягдал**

Алт агуулсан элсийг бүх талаас нь бохирдуулахаар төлөвлөсөн тул уурхайгаас олборлох үед хаягдал үүсэхгүй бөгөөд харин элсийг тээвэрлэх, баяжуулах хэсгийн дэргэд дэх овоолгын талбай, буу тэжээх хэсгүүдэд үүсэхийг хаягдлыг 1% байхаар төлөвлөсөн.

**Ил уурхайн хүчин чадал, уулын ажлын горим, төлөвлөлт**

Олборлолтын хүчин чадлыг сонгохдоо захиалагч компаниас ирүүлсэн техникийн даалгаварт заасанчлан 2 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн бөгөөд уурхайн жилийн хүчин чадал алт агуулсан элсээр 59 мян.м$^3$ байна.

Нийт ашиглалтын хугацаанд 288.9 мян.м$^3$ хөрс хуулж, 177.48 мян.м$^3$ элс олборлон баяжуулна. Хөрс хуулалтын дундаж коэф 2.46 м$^3$/м$^3$. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөг ашиглалтын жил бүрээр дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4. Уулын ажлын кадендарчилсан төлөвлөлт

| № | Үндсэн үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Ашиглалтын жилүүд | | | | | | НИЙТ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1-р жил | | Нийт | 2-р жил | | Нийт | |
| | | | I хагас | II хагас | | I хагас | II хагас | | |
| 1 | Уулын цул | мян.$м^3$ | 114.31 | 101.23 | 215.54 | 124.69 | 66.17 | 190.87 | 406.41 |
| 2 | Хөрс хуулалт | мян.$м^3$ | 86.99 | 70.00 | 156.99 | 87.72 | 44.22 | 131.94 | 288.93 |
| 3 | Элс олборлолт | мян.$м^3$ | 27.32 | 31.23 | 58.55 | 36.97 | 21.95 | 58.93 | 117.48 |
| 4 | Дундаж агуулга | мгр/$м^3$ | 263.00 | 159.34 | 207.71 | 147.16 | 369.06 | 229.83 | 218.80 |
| 5 | Шлих, кг | кг | 7.18 | 4.98 | 12.16 | 5.44 | 8.10 | 13.54 | 25.71 |
| 6 | Химийн цэвэр, кг | кг | 6.65 | 4.60 | 11.25 | 5.03 | 7.49 | 12.53 | 23.78 |
| 7 | Хөрс хуулалтын дундаж итгэлцүүр | $м^3/м^3$ | 3.18 | 2.24 | 2.68 | 2.37 | 2.01 | 2.24 | 2.46 |

**Ил уурхайн уулын ажлын горим**

Уг ордын уулын ажил нь улирлын чанартай явагдах бөгөөд 6-р сарын 2-ноос 6-р сарын 15-ныг хүртэл бэлтгэл ажил, 6-р сарын 15-наас 10-р сарын 31-нийг хүртэл элс олборлолт, хөрс хуулалт, элс угаан баяжуулалтын ажил явагдах буюу жилийн хугацаанд 4.5 сар ажиллахаар төлөвлөж байна.

Уурхайн хөрс хуулалтын ажил нь хоногт 12 цагийн 2 ээлжээр, харин элс олборлох угаан баяжуулах хэсэг нь 1 ээлжээр ажиллах горимыг барина.

**Уулын ажлын өрнөл дараалал**

Сэртэнгийн алтны шороон ордыг 2 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн бөгөөд уурхайн ашиглалтаар нийт дөрвөн тусдаа ил уурхай үүснэ. Ашиглалтын эхний жилд ил уурхай 1, ил уурхай 2, ил уурхай 3 гэсэн нийт 3-н ил уурхайн хүрээнд уулын ажил явуулахаар төлөвлөгдсөн бол ашиглалтын 2 дахь жилд ил уурхай 1, ил уурхай 4 дээр уулын ажил явагдана. Ордын нөөц бага, нөөцийн хэсэгшлүүдийн хучаас хөрсний зузаан харилцан адилгүй тул байгаа тул бид ашиглалтын 2 жил дэх хөрс хуулалт, элс болон алт олборлолтын хэмжээ харьцангуй тогтвортой байх боломжийг эрэлхийлэн уурхайн ашиглалтын дарааллыг тодорхойлсон. Уулын ажлын дарааллыг дараах хүснэгтэд үзүүллээ.

Хүснэгт 5. Уурхайн уулын ажил явагдах дараалал

| № | Ашиглалтын жилүүд | Үе шат | Уурхайн дугаар | Хамаарах нөөцийн хэсэгшил |
|---|---|---|---|---|
| 1 | I жил | I хагас | Ил уурхай-3 | B-26, B-27, B-28, B-29, B-30, B-31 |
| | | II хагас | Ил уурхай-3 | B-25, B-24, C-23 |
| | | | Ил уурхай-2 | C-20, C-21, C-22 |
| | | | Ил уурхай-1 | B-17, B-18, C-19 |
| 2 | II жил | I хагас | Ил уурхай-1 | B-7, B-8, B-9, B-10, B-11, B-12, B-13, B-14, B-15, B-16 |
| | | II хагас | Ил уурхай-4 | B-32, B-33, B-34, B-35, B-36, B-37 |

**Уурхайн нээлт**

Сэртэн нэртэй алтны шороон орд нь нөөц тооцоолсон нийт 4 хэсгээс бүрдэх бөгөөд хэсэг тус бүр дээр нээлтийн ажил хийгдэх юм. Бид нөөц тооцоолсон үндсэн 4 хэсгийг зүүн урд хэсгээс нь эхлүүлэн ил уурхайг дугаарласан. Ил уурхай тус бүрийг нээх ерөнхий төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүллээ.

Хүснэгт 6. Уурхайн нээлтийн төлөвлөгөө

| № | Ашиглалтын жилүүд | Үе шат | Уурхайн дугаар | Нээлт хийх нөөцийн хэсэгшил | Нээх арга |
|---|---|---|---|---|---|
| 1 | I жил | I хагас | Ил уурхай-3 | B-31 | Налуу траншей |
| | | I хагас | Ил уурхай-2 | C-20 | Бульдозерийн үргэлжилсэн гарц |
| | | | Ил уурхай-1 | C-19, B-18 | Налуу траншей |
| 2 | I жил | II хагас | Ил уурхай-4 | B-37 | Бульдозерийн үргэлжилсэн гарц |

Ашиглалтын 1-р жилийн I хагаст ил уурхайн-3 –ын B-31 нөөцийн хэсэгшлийн хөрсийг экскаватор автосамосвалын хослолоор хөрсний гадаад овоолготой байхаар нээлтийн ажил эхэлнэ. Нээлтийн ажлын хэмжээ нь 10 мян.м3 хөрс хуулж 2.35 мян.м3 алт агуулсан элсний нөөцийг олборлоход бэлдэн нээх юм. Уурхайн нээлт эхлэх солбицол нь X=629807.54 Y=5101435.96. Ил уурхай-3 –ын нээлтийн ажлын зургийг дараах хүснэгтэд харуулав.

Зураг 4. Ил уурхай 3- ийн нээлт




Ашиглалтын 1-р жилийн II хагаст ил уурхайн-2 –ын C-22 нөөцийн хэсэгшлийн хөрсийг хөндлөн чиглэлд бульдозероор гадаад овоолго үүсгэн нээлтийн ажил хийгдэнэ. Нээлтийн ажлын хэмжээ нь 11.9 мян.м$^3$ хөрс хуулж 2.95 мян.м$^3$ алт агуулсан элсний нөөцийг олборлоход бэлдэн нээх юм. Уурхайн нээлт эхлэх солбицол нь X=632440.21 Y=5100797.47. Ил уурхай-2 –ын нээлтийн ажлын зургийг дараах хүснэгтэд харуулав.

Зураг 5. Ил уурхай 2- ийн нээлт




Ашиглалтын 1-р жилийн II хагаст ил уурхайн-1 –ын С-19 болон В-18 нөөцийн хэсэгшлийн хөрсийг экскаватор автосамосвалын хослолоор хөрсний гадаад овоолго үүсгэн нээлтийн ажил хийгдэнэ. . Нээлтийн ажлын хэмжээ нь 9.9 мян.м3 хөрс хуулж 6.4 мян.м3 алт агуулсан элсний нөөцийг олборлоход бэлдэн нээх юм. Уурхайн нээлт эхлэх солбицол нь X=633457.21 Y=5100297.76. Ил уурхай-1 –ийн нээлтийн ажлын зургийг дараах хүснэгтэд харуулав.

Зураг 6. Ил уурхай 1- ийн нээлт




Ашиглалтын 2-р жилийн II хагаст ил уурхайн-4 –ийн В-37 нөөцийн хэсэгшлийн хөрсийг бульдозероор хөндлөн чиглэлд түрж хөрсний гадаад овоолго үүсгэн нээлтийн ажил хийгдэнэ. . Нээлтийн ажлын хэмжээ нь 8.4 мян.м$^3$ хөрс хуулж 3.2 мян.м$^3$ алт агуулсан элсний нөөцийг олборлоход бэлдэн нээх юм. Уурхайн нээлт эхлэх солбицол нь X= 26831.4 Y=5103305. Ил уурхай-4 –ийн нээлтийн ажлын зургийг дараах хүснэгтэд харуулав.

Зураг 7. Ил уурхай 4- ийн нээлт




**Уулын ажлын 1-р жилийн төлөвлөлт**

***Уулын ажлын 1-р жилийн төлөвлөлт /эхний хагас/:*** Ашиглалтын эхний жилийн I хагаст нөөцийн B-31 хэсэгшлээс уулын ажил эхэлнэ. B-31 хэсэгшил нь ордын төвийн баруун хэсгийн хамгийн баруун зах хэсэгт орших учир уурхайн ахилт нь зүүн тийш чиглэлтэй байна. B-31 хэсэгшлийн 10 мян.м$^3$ хөрсийг экскаватор автосамосвалын хослолоор ухаж ачин тээвэрлэж тухайн хэсэгшлийн урд талд хөрсний гадаад овоолгод хураана. Үүний дараагаар B-30->B-27 хүртэл хэсэгшлүүдийн хөрсийг уурхайн ашиглагдсан хоосон орон зай руу бульдозер болон экскаватор автосамосвалын хослолоор шилжүүлэн дотоод овоолго үүсгэхээр төлөвлөгдсөн. Уурхайн үйл ажиллагаанаас хамаарч эвдрэлд өртөх талбайн хэмжээг бага байлгах, техникийн нөхөн сэргээлтийн зардлыг бууруулах зорилгын хүрээнд элс тээврийн автосамосвалууд нь хоосон чиглэлдээ угаан баяжуулах хэсгээс гарсан хаягдал галь болон эфелийг тээвэрлэн ирж уурхайн ашиглагдсан хоосон орон зайд хийгдэж буй дотоод овоолгод буулгахаар төлөвлөсөн.

Ашиглалтын 1-р жилийн эхний хагаст 87 мян.м$^3$ хөрс хуулж, 27.5 мян.м$^3$ элс олборлоно. Хөрсний дундаж зузаан нь 1.78 м, элсний дундаж зузаан нь 0.4м. Уулын ажлын дэлгэрэнгүй тооцоог дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 7. Уурхайн эхний жилийн 1-р хагасын уулын ажлын хэмжээ

| Блокийн дугаар | Хөрс хуулалт | Элс олборлолт | Дундаж агуулга | Алтны нөөц, (шлих) | Алтны нөөц, (х.цэвэр) |
|---|---|---|---|---|---|
| | мян.$м^3$ | мян.$м^3$ | мгр/$м^3$ | кг | кг |
| B-25 | 10.13 | | | | |
| B-26 | 12.19 | 3.07 | 171 | 0.53 | 0.49 |
| B-27 | 16.29 | 6.89 | 210 | 1.45 | 1.34 |
| B-28 | 15.20 | 7.84 | 244 | 1.91 | 1.77 |
| B-29 | 12.32 | 4.44 | 295 | 1.31 | 1.21 |
| B-30 | 10.87 | 2.73 | 225 | 0.62 | 0.57 |
| B-31 | 10.01 | 2.35 | 584 | 1.37 | 1.27 |
| Нийт | 86.99 | 27.32 | 263 | 7.18 | 6.65 |




Зураг 8. Уурхайн 1-р жилийн I хагасын эцсийн байдал

Уулын ажлын 1-р жилийн төлөвлөлт /сүүлийн хагас/: Ашиглалтын эхний жилийн II хагаст нөөцийн B-25 хэсэгшлээс элс олборлолтын ажил эхлэх бөгөөд B-24 болон C-23 хэсэгшлүүдийг үргэлжлүүлэн олборлож дууссанаар ордын төв*ийн баруун /ил уурхай 3/* хэсгийн нөөцийг бүрэн ашиглаж дуусах юм. Үүний дараагаар энэхүү төв *баруун /ил уурхай 3/* хэсгээс зүүн урагшаа 1.1 км зайд орших *төвийн зүүн /ил уурхай 2/ хэсгийн* C- 22, C-21, C-20 хэсэгшлүүдэд уулын ажлыг үргэлжлүүлэн явуулна.

Ил уурхай 2-д хамаарах C-22, C-21, C-20 хэсэгшлүүдийн хөрсний дундаж зузаан 1.5 м, элсний дундаж зузаан нь 0.4 м байна. Энэхүү хэсэгшлүүдийн хучаас хөрсний зузаан харьцангуй нимгэн бөгөөд хэсэгшлийн 2 захаараа овоолго үүсгэх боломжит талбайтай учир төсөл хэрэгжүүлэгчид ашиглахад бэлэн байгаа shantui SD-22 маркийн бульдозер ашиглан хөрсийг хөндлөн чиглэлд түрж овоолго үүсгэхээр төлөвлөсөн. Энэ нь хөрс хуулалтын зардлын бага байлгах боломжийг бүрдүүлнэ.

Ашиглалтын эхний жилийн II хагасын төгсгөл хэсэгт ордын зүүн урд талд орших ил уурхай 1-д хамаарах хэсгийн C-19, B-18, B-17 нөөцийн хэсэгшлүүдэд олборлолт явуулна. C-19 болон B-18 блокийн тал хөрс буюу нийт 8 мян.$м^3$ хөрсийг экскаватор автомасосвалын хослолоор хуулж хөрсний гадаад овоолго үүсгэнэ. Үүний дараа B-18, B- 17 блокуудын хөрсийг олборлолт явагдсан хоосон орон зай руу түрж дотоод овоолго үүсгэхээр төлөвлөсөн. Нийтдээ 1-р жилийн сүүлийн хагаст 70 мян.$м^3$ хөрс хуулж, 31.23 мян.$м^3$ элс олборлоно. Уулын ажлын дэлгэрэнгүй тооцоог дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 8. Уурхайн эхний жилийн II хагасын уулын ажлын хэмжээ

| Блокийн дугаар | Хөрс хуулалт | Элс олборлолт | Дундаж агуулга | Алтны нөөц, (шлих) | Алтны нөөц, (х.цэвэр) |
|---|---|---|---|---|---|
| | мян.$м^3$ | мян.$м^3$ | мгр/$м^3$ | кг | кг |
| B-17 | 4.79 | 2.37 | 155 | 0.37 | 0.34 |
| B-18 | 8.13 | 5.14 | 128 | 0.66 | 0.61 |
| B-24 | 16.07 | 6.63 | 127 | 0.84 | 0.78 |
| B-25 | - | 5.02 | 111 | 0.56 | 0.52 |
| C-19 | 3.91 | 2.68 | 126 | 0.34 | 0.31 |
| C-20 | 9.00 | 1.95 | 125 | 0.24 | 0.23 |
| C-21 | 9.77 | 2.43 | 261 | 0.64 | 0.59 |
| C-22 | 11.98 | 2.95 | 354 | 1.04 | 0.97 |
| C-23 | 6.35 | 2.05 | 140 | 0.29 | 0.27 |
| Нийт (B) | 28.99 | 19.16 | 127 | 2.43 | 2.24 |
| Нийт( C) | 41.01 | 12.07 | 211 | 2.55 | 2.36 |
| Нийт (B+C) | 70.00 | 31.23 | 159 | 4.98 | 4.60 |




Зураг 9. Уурхайн 1-р жилийн II хагасын эцсийн байдал

## Уулын ажлын 2-р жилийн төлөвлөлт

Уулын ажлын 2-р жилийн төлөвлөлт /эхний хагас/: Ашиглалтын 2-р жилийн эхний хагаст ил уурхай 1-д хамаарах нөөцийн B-16 хэсэгшлээс B-7 хүртэл нийт бодитой B зэргийн 10 хэсэгшлүүдэд уулын ажил явагдана. B-16 блокийн хөрсийг экскаватор автосамосвалын хослолоор ухаж тээвэрлэн 1-р жилийн 2-р хагаст Ил уурхай 1-ийн B-17 хэсэгшлийн ашиглалтаар үүссэн ашиглагдсан хоосон орон зайд дотоод овоолго үүсгэн овоолохоор төлөвлөсөн. 2 дахь жилийн эхний хагаст нийт 87.7 мян.м$^3$ хөрс хуулж, 36.97 мян.м$^3$ элс олборлож угаан баяжуулах хэсэг рүү тээвэрлэнэ.

Хөрсний дундаж зузаан нь 1.7 м, элсний дундаж зузаан нь 0.46 м байна. Уулын ажлын дэлгэрэнгүй тооцоог дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 9. Уурхайн 2-р жилийн I хагасын уулын ажлын хэмжээ

| Блокийн дугаар | Хөрс хуулалт | Элс олборлолт | Дундаж агуулга | Алтны нөөц, (шлих) | Алтны нөөц, (х.цэвэр) |
|---|---|---|---|---|---|
| | мян.$м^3$ | мян.$м^3$ | мгр/$м^3$ | кг | кг |
| B-7 | 2.61 | 0.98 | 185 | 0.18 | 0.17 |
| B-8 | 7.74 | 1.66 | 317 | 0.53 | 0.49 |
| B-9 | 7.04 | 2.65 | 159 | 0.42 | 0.39 |
| B-10 | 8.79 | 4.65 | 132 | 0.61 | 0.57 |
| B-11 | 15.02 | 6.94 | 105 | 0.73 | 0.68 |
| B-12 | 15.56 | 6.63 | 108 | 0.72 | 0.66 |
| B-13 | 7.87 | 3.46 | 124 | 0.43 | 0.40 |
| B-14 | 7.33 | 3.54 | 193 | 0.68 | 0.63 |
| B-15 | 9.91 | 4.00 | 190 | 0.76 | 0.70 |
| B-16 | 5.86 | 2.46 | 152 | 0.37 | 0.35 |
| Нийт | 87.72 | 36.97 | 147 | 5.44 | 5.03 |

Зураг 10 . Уурхайн 2-р жилийн 1-р хагасын эцсийн байдал




Уулын ажлын 2-р жилийн төлөвлөлт /эхний хагас/: Ашиглалтын 2-р жилийн сүүлийн хагаст ордын баруун хойд хэсэгт орших ил уурхай 4-д хамаарах нөөцийн B-32 хэсэгшлээс B-37 хүртэл нийт 6 нөөцийн хэсэгшилд уулын ажил явагдана. Энэхүү хэсгийн хөрсний дундаж зузаан нь 1 м, элсний дундаж зузаан нь 0.4м байх бөгөөд хучаас хөрсний зузаан харьцангүй нимгэн тул B-37 хэсэгшлийн хөрсийг бульдозероор хөндлөн чиглэлд түрж шилжүүлэх замаар үргэлжилсэн гарцаар нээхээр төлөвлөсөн. B-36 блокийн урд хил тусгай зөвшөөрлийн хилтэй ойрхон тул урд хэсгийн хөрсийг экскаватор автосамосвалын хослолоор B-35 блокийн хоосон орон зайд дотоод овоолго үүсгэнэ.

Ашиглалтын 2-р жилийн сүүлийн хагаст 44.22 мян.м$^3$ хөрс хуулж, 21.95 мян.м$^3$ элс олборлоно. 2-р жилийн сүүлийн хагасын уулын ажлын дэлгэрэнгүй тооцоог дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 10. Уурхайн 2-р жилийн сүүлийн хагасын уулын ажлын хэмжээ

| Блокийн дугаар | Хөрс хуулалт | Элс олборлолт | Дундаж агуулга | Алтны нөөц, (Шлих) | Алтны нөөц, (Х.Цэвэр) кг |
|---|---|---|---|---|---|
| | мян.м$^3$ | мян.м$^3$ | мгр/м$^3$ | кг | кг |
| B-32 | 5.70 | 3.98 | 559 | 2.22 | 2.06 |
| B-33 | 4.31 | 2.44 | 531 | 1.30 | 1.20 |
| B-34 | 5.22 | 3.32 | 289 | 0.96 | 0.89 |
| B-35 | 8.88 | 4.02 | 141 | 0.57 | 0.53 |
| B-36 | 11.69 | 4.99 | 318 | 1.59 | 1.47 |
| B-37 | 8.42 | 3.21 | 458 | 1.47 | 1.36 |
| Нийт | 44.22 | 21.95 | 369 | 8.10 | 7.49 |

Зураг 11. Уурхайн 2-р жилийн 2-р хагасын эцсийн байдал




## Ил үндсэн болон туслах тоног, төхөөрөмж

Үндсэн тоног төхөөрөмжүүдийн иж бүрдэл: Ил уурхайн хэлбэр хэмжээ, орон зай, чулуулгийн шинж чанар, элс хөрсний зузаан зэрэг суурь нөхцөлүүдийг үндэслэн дараах технологи, механикжуулалтын бүтэц нь хөрс хуулалт, овоолго, олборлолтын ажилд тохиромжтой гэж үзлээ.

Бид хөрс хуулалтын ажлыг эдийн засгийн хувьд хэмнэлттэй байх боломжит хувилбарыг сонгохын тулд экскаватор автосамосвалын хослол болон бульдозерын харьцуулсан тооцооллыг гүйцэтгэсэн бөгөөд уг тооцооллын үр дүнд уурхайн 1.5 метрээс дээш зузаантай хөрсийг хуулах ажилд экскаватор автосамосвалын хослол, 1.5 метрээс бага

зузаантай хэсэгт бульдозер ашиглах нь үр дүнтэй байгааг тодорхойлсон. Харин алт агуулсан элс олборлох ажилд экскаватор болон автосамосвалын хослолыг ашиглана.

Хүснэгт 11. Тоног төхөөрөмжийн иж бүрдэл

| № | Ажлын төрөл | Тоног төхөөрөмжийн төрөл | Тоног төхөөрөмжийн нэр |
|---|---|---|---|
| 1 | Хөрс хуулалт | Экскаватор, бульдозер | Hyundai R300LC-9, Shantui SD22 |
| 2 | Элс олборлолт | Экскаватор | Liugong 925E |
| 3 | Тээвэрлэлт | Автосамосвал | HOWO |

# 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 2.1.Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

**Газрын гадаргуу:** Өлзийт сумын нутаг дэвсгэр нь монгол орны физик газарзүйн мужлалаар Хангайн нурууны өвөр хэсэгт Байдраг, Өлзийт голын  савд оршино. Тус аймгийн нутаг нь физик газарзүйн мужлалаар хойд хэсгээрээ Хангайн их уулт мужид, төв, урд хэсгээрээ Алтайн говийн мужид, төв хэсгийн урд талаараа Говь Алтайн их уулт мужид тус тус хамрагдаж байна.

Төслийн талбай нъ 2426 м-ийн үнэмлэхүй өндөрт байрладаг. Талбайн усан хагалбар болох нам уулс, гүвээ нь өргөргийн дагуу чиглэлтэй урт, нарийн сунасан тогтоцтой бөгөөд энэ нь тухайн районы тектоник эвдрэлийн чигтэй давхацдаг. Тухайн районд тогтмол урсгалтай гол, горхи байхгүй, гадаргуугийн усан хангамж муутай бүс нутаг юм.
Төслийн талбайн район далайн түвшнээс дээш 2203 метрийн өндөрт байрлаж, газрын гадаргын налуу буюу хэвгий 4.80 (градуст) байна.

**Усан сүлжээ***:* Уг талбай нь усан хангамжийн хувьд ядуувтар. Жилд унах тунадасны хэмжээ бага. Усан сүлжээ сул хөгжсөн бүс нутагт хамаарна. Талбай орчимд жижиг хуурай сайр жалгууд ихтэй бөгөөд эдгээр хуурай сайрууд нь бороотой үед хүчтэй ирэх үерийн усаар угаагддаг. Ордын талбайн зүүн талаар Түйн гол урсан өнгөрдөг байна. Талбайд нуур болон тогтоол ус тааралддаггүй байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Сэртэн” алтны шороон орд нь Хангайн нурууны өвөр энгэр – Түйн голын ай савд багтана.

**Цаг агаар, уур амьсгал:** Баянхонгор аймаг нь 116.0 мянган дөрвөлжин километр нутагтай, далай түвшнээс дээш 974-2435м хүртэл өндөр өргөгдсөн, газар нутгийн хотгор гүдгэрийн ялгаа ихтэй зэрэг нь агаарын температур, хур тунадасны газар зүйн хуваарилалтанд ихээхэн нөлөөлж бүс нутгийн хувьд жил, сарын температур, хур тунадас жигд биш байдаг билээ.

Судалгааны талбай нь эх газрын эрс тэс цаг уууртай, Дөвөнт, Жаргалантын нуруу, Заг, Байдраг голын эх орчим өндөрлөг, эрт сэрүү орж, өвөлд хүйтэн, цас их ордог онцлогтой. Агаарын температурын жилийн дундаж зөрүү нь 6°, температурын хэлбэлзэл нь 69°, зарим өвлийн идэр гурван есийн хүйтэн нь 1-р сард -43.5° хүрдэг байхад зун 7-р сард +25.5° дээш байна. Жилийн дундаж тунадас нь 276 мм, үүний 85-90% нь зуны улиралд 10-15% нь бусад улиралд унадаг байна. Жилд баруун хойт зүгээс салхилдаг, салхины хүч нь хамгийн их үедээ 25 м/сек хүрдэг.

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд олон жилийн дундаж агаарын температур нутгийн хойд хэсгээр -8...-4°C, төвийн хэсгээрээ -2...+4°C харин урд хэсгээр +6...+8°C байна. Харин жилийн нийлбэр хур тунадас нутгийн хойд хэсгээр 200...400 мм, төвийн хэсгээрээ 50-150 мм харин урд хэсгээр 50...100 мм унадаг байна.

**Ургамлан нөмрөг:** Баянхонгор аймгийн Өлзийт сум болон төслийн талбайн нутаг дэвсгэр нь Монгол орны байгалийн мужлалаар  хуурай  хээрийн бүсэд багтана.

Энэ газар нутаг нь ургамал газарзүйн мужлалын хувьд Төслийн талбай, түүний орчмын газар нутаг нь Монгол орны ургамал газарзүй нь мужлалаар Евроазийн хээрийн их муж Өмнөд Хангай уулын хээрийн тойрогт хамаарна. (Үндэсний атлас, 1990).

Ургамлын хээрийн судалгааг хийхдээ экологи, ургамлан бүлгэмдлийн бүтэц бүрэлдэхүүн онцлогоос харгалзан төслийн талбайд хэмжилт судалгааг явуулсан. Ургамлын судалгааг 2024 оны 11 дугаар сард ургамлын 5 бүрэн бичиглэл хийж зүйлийн бүрэлдэхүүн, ургамлан бүрхэвч, биомасс зэргийг тодорхойлсон.

Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт бэлчээрийн зонхилогч зүйл нь *Stipa krylovii*-крыловын Хялгана, дэд зонхилогч зүйл нь *Agropyron cristatum*-саман Ерхөг*, Cleistogenes squarrosa*-дэрвээн Хазаар өвс зэрэг үетэн ургамлууд бүрдүүлж байна. Үүний зэрэгцээ *Carex duriuscula*-ширэг Улалж, *Caragana stenophylla*-нарийн Харгана, *Heteropapus hispidus*-арзгар Согсоолж, *Elymus chinensis*-нангиад Түнгэ зэрэг ургамлууд зонхилон ургасан.

**Амьтны аймаг:** Тухайн бүс нутагт ан амьтад харьцангуй элбэг, махчин амьтдаас үнэг, хярс, дорго, мануул, хаая чоно, салаа туурайтнаас аргаль угалз, янгир, хавар намартаа зээр нүүдэллэн ирдэг ба Алтай Хангайн уулсаар аргал, янгир, ирвэс шилүүс, буга, бор гөрөөс, гахай, хүдэр, дорго Говийн бүсэд хар сүүлт, хавтгай, мазаалай, хулан, зэгээсний гахай зэрэг дархан цаазтай, улаан номд орсон амьтад, тал хээрт цагаан зээр байдгаас гадна аль ч бүсэд тарвага, үнэг, чоно, хярс, мануул зэрэг үслэг ан элбэг. Говийн нүцгэн хуруут гүрвэл, тэмээн сүүлт могой зэрэг хэвлээр явагчид, бүргэд, ёл, цасны хажир, тас, шонхор, хойлог, ятуу, хулан жороо, хуруут хун, хээрийн галуу, ангир, нугас, тоодог, халбаган хушуут, итэлгэн цахлай, өрөвтас, зэрэг 150 гаруй шувуу бүртгэгджээ. Тарвага агналтаар улсад тэргүүн байрт орж байсан боловч одоо энэ амьтан ховор амьтдын тоонд орохоор болоод байна. Зэвэг, алгана, зурхай, хадран зэрэг цөөн төрлийн загастай.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд 2001-2010 оны сүүлийн 10-аад жилд аргаль хонины тархац улсын хэмжээнд 3 %-иар нэмэгджээ. Зарим аймгуудын нутагт аргаль хонины тоо төдийлөн өсөөгүй ч тархац нутаг нь нэлээд өссөн дүнтэй байна.

**Дэд бүтэц:** Тус сумын төв нь Баянхонгор аймгийн зүүн урд хэсэгт 17 км, Улаанбаатар хотоос 613 км зайд оршдог. Нутгийн зүүн хэсгээрээ Өвөрхангай аймгийн Уянга, Нарийн тээл, Баруунбаян-Улаан сум, урд хэсгээрээ өөрийн аймгийн Богд, Жинст сум, баруун хэсгээрээ Баян-Овоо сум, хойд хэсгээрээ Эрдэнэцогт сумдтай тус тус хиллэдэг.

Тус сум нь байгалийн үзэсгэлэнт тогтоц, түүхэн дурсгалт газрууд, ховор ан амьтад, ургамлын төрөл зүйлээр баялаг, хангай, тал хээр хосолсон 385283 га бүхий өргөн уудам нутагтай. Засаг захиргааны нэгж Бурхант, Байн-Ам, Ёлын-Ам, Худаг-Урт, Бийрийн Уулзвар, Улаан-Уул гэсэн 6 багт 1165 өрхийн 3907, үүнээс эрэгтэй 1959, эмэгтэй 1948 хүн амьдардаг.

Зам тээвэр. Баянхонгор аймгийг Улаанбаатар хоттой холбосон улсын чанартай 56 км авто зам сумын нутгаар дайран өнгөрдөг. Худаг Урт 4-р баг засмал замаар, Бийрийн Уулзварын 5-р баг, Ёлын Ам 3-р багууд сайжруулсан шороон замаар тус тус холбогдсон. Сумын төвд 1060м хатуу хучилттай, гэрэлтүүлэг бүхий авто замтай.

Харилцаа холбоо. Үүрэн холбооны Жи-Мобайл, Юнител Скайтелын 2G сүлжээ нь сумын нутаг дэвсгэрийн 80 хувийг, Юнител, Мобиком 4G сүлжээ нутаг дэвсгэрийн 40 хувьд нэвтэрснээр мэдээ мэдээлэл хүлээн авах, дамжуулах нөхцөл боломж бүрдсэн.

Төрийн үйлчилгээний байгууллагуудад Мобикомын шилэн кабельд холбогдсоноор төрийн үйлчилгээ цахимжсан.

Цахилгаан хангамж. Аймгийн эрчим хүчний системд 1985 онд, Эрдэнэт Булганы цахилгаан түгээх төвийн эрчим хүчний системд 2000 онд холбогдож 6800кВт-ын өндөр хүчдэлийн эх үүсвэрээр хангагдсан.

# 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

## 3.1.Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Тус төслийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь агаар, ус, хөрс, ургамлан нөмрөг юм.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

Хүснэгт 12. Байгаль орчны сөрөг нөлөөллийн үзүүлэлтүүд

| Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд | Сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй нөхцөлүүд |
|---|---|
| Төслийн байршилтай холбоотой шалгуурууд | |
| Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх | Төсөл хэрэгжих талбай нь  тусгай хамгаалалттай газар нутгуудтай давхцалгүй байна. |
| Хүний нөлөө болон байгаль, цаг уурын өөрчлөлтөд эмзэг, эсэх | Баянхонгор аймгийн цаг уурын өртөө харуулын хэмжилтээр авч үзвэл агаарын температурын олон жилийн дундаж хангайн бүсэд -3.80С, хээрийн бүсэд 1.60С, говийн бүсэд 4.50С байна. Баянхонгор аймгийн газар нутаг нь Алтай, Хангай нурууны хоорондох өргөн уудам нутагтай орох хур тунадасны хэмжээ газар зүйн өвөрмөц хуваарилалтай.  Уур амьсгалын дунджаар жилд Хангайн гол нуруудын орчимд  190-230мм  үгнээс их, салбар уулсын орчим 150-190 мм орчим хур тунадас ордог. Аймгийн төвийн хэсэг, Алтайн нурууны салбар уулсад орших нутгуудад 95-150мм хур тунадас буудаг байхад говийн өмнөд хэсэгт 90мм-ээс бага хур тунадас унадаг.<br>Баянхонгор аймгийн нутагт жилийн дулааны улиралд болох 4-10 сард  нийт орох хур тунадасны 90-94% нь ордог нь Монгол орны хур тунадасны горим манай аймаг тод илэрдэг.<br>Тогтвортой цаг агаар ноёлох өвлийн /11-3сар/ улиралд аймгийн нийт нутгаар уур амьсгалын дунджаар 4.9-өөс 14.6 мм хур тунадас орох бөгөөд 1, 2 сард 0.4-өөс 3 мм орчим унадаг. Баянхонгор аймгийн нутагт монгол орны бусад нутгийн адил хойд, баруун хойд чиглэлийн салхи голчлон давтагддаг. Салхины зонхилох чиглэл улирал сар бүрд нутгийн онцлогоос болж өвөрмөц боловч салхины ерөнхий горим хадгалагдаж байдаг.  Судалгааны үр дүнгээр харахад: Өвлийн улиралд баруун  хойноос 27.3 хувь, хойноос 24.8 хувь, баруунаас 6.2 хувь зүүн хойноос 9 хувь, салхигүй үеийн давтагдал 20.2 хувь байгаагаас харахад баруун хойд болон хойд чиглэлийн салхи ноёлж байна.<br>Хаврын улирлын салхины чиглэл баруун  хойд чиглэлээс 30.0 хувь, баруунаас 20 хувь,  хойноос 13.1 хувь, зүүн хойноос 3.0 хувь, баруун өмнөөс 3.0 хувь, салхигүй үеийн давтагдал 10.1 хувь байдаг байна.<br>Зуны улиралд  салхины  зонхилох чиглэлийн давтагдал  нь  баруун |

| Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд | Сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй нөхцөлүүд |
|---|---|
| | хойноос 17.5 хувь, баруунаас 16 хувь, хойноос 9.7 хувь, бусад бүх чиглэлээс 7 хувь, салхигүй үеийн давтагдал 20.6 хувь байдаг.<br>Намрын улиралд салхины зонхилох чиглэл нь баруун хойноос 28.0 хувь, баруунаас 16 хувь, хойноос 15.4 хувь, зүүн хойноос 4.0 хувь, салхигүй үеийн давтагдал 12.6 хувь байгаа нь хаврын улиралтай ойролцоо давтагдалтай байна.<br>Салхины хурд, хөрсний байдалтай уялдан шороон шуургатай өдрийн тоо түүний эрч хүч газар бүр харилцан адилгүй байдаг. Жилд дунджаар хангай бүсийн нутгаар 25 өдөр, тал хээрийн бүсийн нутгаар 34 өдөр, говийн бүсийн нутгаар 38 өдөр шороон шуургатай байдаг |
| Орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байгаа эсэх | Төслийн үргэлжлэх хугацаа их, хэтийн төлөвлөлт бүхий газар байхгүй |
| Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх | Төслийн үргэлжлэх хугацаанд хуримтлагдах нөлөөлөл үүснэ. |
| Төслийн БО-ны нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд | |
| Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл:<br>- Бохирдуулагч болон аюултай, хортой бодис ялгаруулах, эсэх<br>- Дуу чимээ, доргио чичиргээ, дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсгэх, эсэх | - Уурхайн тээвэрлэлтийн үед үүсэх тоосжилт;<br>- Уурхай ашиглалтын үед үүсэх тоос<br>- Техник тоног төхөөрөмжийн дуу чимээ |
| Усан орчинд үзүүлэх нөлөөлөл:<br>- Усны нөөцөд хомсдол үүсэх, эсэх<br>- Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх<br>- Ус бохирдуулах, эсэх | Уурхайн усан хангамжийг өөрийн талбайд гаргасан гүний худгийн усаар хангана. |
| Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөө:<br>- Хөрс эвдрэх эсэх<br>- Хөрс бохирдох эсэх<br>- Хөрс доройтох цөлжих эсэх | - Бүтээн байгуулалт, тээвэрлэлтийн нөлөөгөөр хөрс эвдэрнэ.; |
| Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө:<br>- Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх<br>- Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйл өртөх эсэх | - Ашиглалтын хугацаанд хөрс хуулснаар ургамлан нөмрөг биет хэмжээгээр устаж ургамалгүй болох;<br>- Газар хөрс талхлагдсан газруудад ургамлан нөмрөг талхлагдан халцрах;<br>- Бүтээн байгуулалт, тээвэрлэлтийн тоосны нөлөөгөөр ургамлын ургах орчин доройтох; |
